



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 19 өдөр

Дугаар А/997

Мандалговь

Төв Халхын дуулалт жүжгийн театрт
дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйл 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Соёлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.1, Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.8, 16.3.10, аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.5.3.1 дэх заалтууд болон аймгийн Засаг даргын зөвлөлийн 2023 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн 04 дүгээр хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Оросын холбооны улсын Эрхүү хотын Залуучуудын театрт 4 жил тутамд зохион байгуулагддаг “Байгаль нуурын сахиус” олон ястан үндэстний хүүхдийн жүжгийн наадамд аймгийн Төв Халхын дуулалт жүжгийн театрын уран бүтээлчид С.Мандахын зохиол, Б.Хишигзаяагийн найруулга “Солгой харандаа” хүүхдийн дуут жүжгээр Монгол Улсаа төлөөлөн оролцоход зориулж санхүүгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2.Дэмжлэгт шаардагдах 10,000,000 (Арван сая) төгрөгийг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Г.Энхтайван), ерөнхий санхүүч (С.Адъяасүрэн) нарт зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг Төв Халхын дуулалт жүжгийн театр (Д.Доржсүрэн)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

4823100780